

## **Д.ДЭЛГЭРСАЙХАН: Валютын ханш огцом хэлбэлзэх үндэслэл байхгүй**

Монголбанкны Валют, эдийн засгийн газрын захирал Д.ДЭЛГЭРСАЙХАНТАЙ ярилцлаа.

**-Төгрөгийн ханш сүүлийн өдрүүдэд огцом суларлаа. Энэ юунаас болсон бол?**

-Төгрөгийн ханш он гарснаас хойш 32 төгрөгөөр буюу хоёр хувиар суларч, банк хоорондын захын энэ сарын 6-ны өдрийн ханш 1428 төгрөгөөр хаагдсан. Ер нь оны эхэнд ханш огцом сулардаг үзэгдэл сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. Тухайлбал, өнгөрсөн оны яг өдийд буюу нэгдүгээр сарын 7-ны өдрийн төгрөгийн ханш оны эхнээсээ хоёр хувиар буюу 26 төгрөгөөр огцом суларч, сарын дунд руу эргээд гурван хувиар огцом чангарсан.

Тэгэхээр зах зээлд оролцогчид ханшийн түр хугацааны сулралтын үед мэдээлэл дутмагаас нэг нэгнийгээ дагаад банкин дахь төгрөгийн хуримтлалаа цуцлан байж ам.долларт хөрвүүлдэг, эргээд ханш чангарахаар алдагдалд ордог, эцэст нь хохироод үлддэг дүр зураг хэвээр байна. Жишээ нь, бэлэн валютын зах \Найман шаргал\ дээр ам.доллар 1470 гарч, 1480 руу дөхөж байсан. Тэгснээ өнөөдөр огцом бууж 1420-руу орлоо. Энэ нь ойрын өдрүүдийн огцом хэлбэлзлийг зах зээлийн жам ёсных биш бөгөөд зохиомол гэдгийг харуулж байгаа юм. Түүнчлэн энэ жилийн хувьд дэлхийн эдийн засгийн тодорхой бус төлөв, дотоодын улс төрийн нөхцөл байдал болон бензин шатахууны үнэ өссөн зэрэг хүчин зүйлс нь иргэд, хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгжийг зах зээлийн аливаа огцом өөрчлөлтөд илүү мэдрэмтгий хандаж, захад огцом хэлбэлзэл үүсэхэд нөлөөлж байна.

**-Тэгэхээр ханшийн энэ огцом сулралт нь түр зуурынх гэсэн үг үү?**

-Макро эдийн засгийн энэ оны төсөөлөл, валютын захын төлөв байдлыг харвал, энэ өдрүүдийн ханшийн огцом хэлбэлзэл нь эдийн засгийн нөхцөл байдалтай нийцгүй байна.

**-Энэ нөхцөлд Монголбанк ямар арга хэмжээ авч байгаа вэ?**

- Юуны өмнө Монголбанкнаас ханшийн талаар баримталж буй бодлогоо дахин дурдах нь зүйтэй гэж бодож байна. Төв банкны зүгээс нэгдүгээрт, төгрөгийн ам.доллартай харьцах ханш нь зах зээлийн суурь хүчин зүйлстэйгээ нийцтэй уян хатан тогтож байх, хоёрдугаарт, богино хугацаанд эрэлт, нийлүүлэлт хэт их зөрүүтэй, зах зээл түүнийг хурдан зохицуулж чадахгүйгээс ханш огцом хэлбэлзэх үед интервенц хийх гэсэн маш тодорхой бодлогыг баримталж байна. Өөрөөр хэлбэл, түр зуурын шинжтэй, зах өөрөө үнийн механизмаараа хурдан зохицуулж чадахгүй нөхцөл байдалд Монголбанк үүссэн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр захад оролцож байна. Энэ удаа ийм нөхцөл байдал бий болсон учраас Монголбанк өнгөрсөн пүрэв гарагийн дуудлага худалдаанд оролцож, 66.3 сая ам.долларыг банк хоорондын захад нийлүүлсэн. Цаашид ч ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр дуудлага худалдаа болон бусад хэрэгслээр дамжуулан оролцох болно.

**-Монголбанк ханшийн иймэрхүү өөрчлөлтөд цаашид бэлэн үү. Гадаад валютын албан нөөц хэр байгаа вэ?**

-Монголбанкны хувьд ханшийн огцом өөрчлөлтийг зөөлрүүлэх нөөц хангалттай байна. Өнгөрсөн хугацааны их хэмжээний валютын дотогшлох урсгалын үед илүүдэл валютыг захаас татаж, нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авснаар гадаад

валютын албан нөөц түүхэн дээд түвшиндээ хүрч, өнөөдрийн байдлаар 2.5 тэрбум ам.доллар байна.

Түүнчлэн энэ нөөцөөс гадна БНХАУ-ын Ардын банктай хийсэн таван тэрбум юаньтай буюу одоогийн ханшаар 800 сая ам.доллартай тэнцэх юань, төгрөгийн своп гэрээ байна. Энэ нь урд хөрштэй хийх импортын санхүүжилтыг төгрөгөөр хийх боломжтой гэсэн үг.

**-Амралтын өдрүүдэд шатахууны үнэ нэмэгдэхэд ханш суларсан нь нөлөөлсөн гэсэн тайлбарыг шатахуун импортлогч нар хэлж байна. Энэ талаар ямар бодолтой байна?**

-Төгрөгийн ханш суларч, импортын барааны үнэ нэмэгдэх нь зах зээлийн зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, энэ нь барааны үнэ өсч байгаа шалтгаан биш зөвхөн илэрч буй шинж тэмдэг гэж хэлж байна. Харин шалтгаан нь бид стратегийн бүтээгдэхүүн болсон нефть боловсруулах үйлдвэрээ одоо хүртэл бариагүй, олборлосон түүхий нефтийг БНХАУ руу экспортлосон хэвээр байгаад байна. Иймд зах зээл хөгжсөн оронд ийм төрлийн бүтээгдэхүүний зах дээрх төрийн оролцоо нь ханшийг чангалж, үнийг буулгах биш, дунд болон урт хугацаанд дотоодын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үүнийгээ хийх хооронд түр хугацаанд Засгийн газраас татварын хөнгөлөлт үзүүлэх, татаас олгох арга хэмжээг авах байдаг. Тиймээс гол асуудлаа шийдвэрлэхгүй мөртлөө зөвхөн ханшаар хөөцөлдөж, асуудлыг зохицуулна гэвэл эдийн засгийн эмзэг байдлаа улам нэмэгдүүлж, хямралд ч хүргэж болзошгүй юм.

**-Цаашид ханш яаж өөрчлөгдөх бол?**

-Дээр хэлсэнчлэн энэ нь макро эдийн засгийн нөхцөл байдлаас тухайлбал, манай улсын гадаад худалдааны нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад зээл зэрэг гадаад нөхцөл байдлаас гадна Засгийн газрын бүтээн байгуулалт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, иргэдийн хэрэглээ, хуримтлал зэрэг валютын захын эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлогч олон хүчин зүйлсээс хамаарна. Миний хувьд 2012 онд хувийн секторын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт үргэлжлэх, экспортын орлого нэмэгдэх, банкны зээлийн өсөлт багасах хандлагатай байгаагаас хувийн салбарын эрэлтийн өсөлт саарах хэдий ч Хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэх бүтээн байгуулалтууд эхэлснээр дотоодын нийт эрэлт нэмэгдэн ханш оны туршид зөвхөн нэг чиглэлд биш, богино хугацаанд суларч, чангарахаар байна.

Тиймээс иргэд, аж ахуйн нэгжүүд Монголбанк болон бусад байгууллагаас олон нийтэд хүргэдэг төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл зэрэг макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй тогтмол танилцаж, зөв мэдээлэлтэй оролцож, оновчтой шийдвэр гаргаж байх нь зүйтэй юм. Түүнчлэн валютын ханшийн эрсдлээс сэргийлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагч банкнаасаа авч, бизнесийн үйл ажиллагаандаа хэрэглэж, дадах нь хамгийн зөв арга юм.

**-Сүүлийн асуултыг танд үлдээе.**

-Монголбанк нь ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр захад оролцож байгаа, цаашид ийм нөхцөл үүссэн тохиолдолд оролцож байх болно гэдгээ дахин хэлмээр байна.

Түүнчлэн валютын ханш нь эдийн засгийн нөхцөл байдлаас хамаараад зөвхөн нэг чиглэлд биш, богино хугацаанд чангарч, суларч байдаг үзүүлэлт тул захад оролцогчид дутуу мэдээлэл дээр тулгуурлан аливаа санхүүгийн шийдвэрийг гаргахгүй байхыг зөвлөө.